

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

### Автобензиний ерөнхий шаардлага:

Монгол улсын MNS 0217:2017 стандартын шаардлагыг хангасан байна.

### Зориулалт, хэрэглээ:

Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй "Бор-Өндөр" уулын баяжуулах үйлдвэр (УБҮ)-ийн, мөн Төв аймгийн Заамар суманд үйл ажиллагаа явуулж буй "Шижир алт" алтны үйлдвэрийн тусгай болон ачааны, хүн тээврийн зориулалтын тээврийн хэрэгслүүдийг ажиллуулахад зориулна.

### Автобензиний физик-химийн болон ашиглалтын үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлт	
		А-80	АИ-92
1	Октаны тоо (шинжилгээний аргаар), багагүй	80	92
2	Экологийн ангилал, багагүй	К2	
3	Хар тугалганы агууламж, мг/дм <sup>3</sup> , ихгүй	5	
4	Уусгагчид угаагдах давирхайн хэмжээ, мг/дм <sup>3</sup> , ихгүй	50	
5	Исэлдэлтийн тогтвор, мин, багагүй	360	
6	Хүхрийн агууламж, мг/кг, ихгүй	500	
7	Бензолын агууламж, эзлэхүүний хувь %, ихгүй	5	
8	Усны агууламж, мг/кг, ихгүй	200	
9	Нийт бохирдол, мг/кг, ихгүй	24	
10	Зэс хавтгайн туршилт (50°C-т 3 цаг)	Ангилал 1	
11	Нягт, 15°C-т, кг/м <sup>3</sup>	725.0-780.0	
12	Өнгө, гадна төрх	Цэвэр, тунгалаг	
13	Төлөв	Шингэн	

### Нэмэлт шаардлага:

1	Бензиний дээрхи техникийн үзүүлэлтэд тодорхойлогдоогүй болон стандартаас зөрсөн тохиолдолд Монгол улсын MNS 0217:2017 стандартаар батлагдсан хүснэгт 1, 2-т тодорхойлсон шаардлага, үзүүлэлтийг үндэслэл болгоно.
2	Бензин нь металл (маргенец, хар тугалга, төмөр зэрэг)-тай чанар сайжруулагч нэмэлт агуулаагүй байна.
3	Нийлүүлэгч /импортлогч, борлуулагч мөн адил/ нь бензинд октаны тоо нэмэгдүүлэгч болон бусад чанар сайжруулагч нэмэлт нэмж, хольж болохгүй.
4	Нийлүүлэхээр санал болгож буй бензинийг техникийн шаардлагад нийцэх эсэхийг тодорхойлох зорилгоор үйлдвэрлэгчийн гарал үүслийн гэрчилгээ, стандартчилал хэмжил зүйн тохирлын гэрчилгээ, магадлан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг тендерийн баримт бичигт хавсарган ирүүлнэ.
5	Нийлүүлэх бензин 2024 оны 2 дугаар сараас хойш бөгөөд нийлүүлэлтээс өмнөх 5 сарын дотор үйлдвэрлэгдсэн байна.